

Монгол улс дахь түрэг судлал нь үндсэндээ хоёр салбараар хөгжиж ирсэн байна. Үүнд: тус улсын нутаг дэвсгэрт байгаа эртний түрэг бичээс, археологийн судлал, монгол улсын казахын ард түмний хэл, түүх, хүн ам зүй, эдийн засаг, соёл, угсаатны зүйг судлах явдал юм.

Монгол улсын нутаг дэвсгэр бол зөвхөн монголчуудын түүх, соёлын төдийгүй дэлхий дахины соёл иргэншилд зохих нөлөө бүхий Төв Азийн нүүдэлчдийн соёлын дурсгалт зүйлийн өлгий билээ. Эдгээрийн дотор эртний түрэг бичээс, археологийн дурсгал хүндтэй байр эзэлдэг. Энэ бүхнийг манай судлаачид анхаарч монгол орны түүх болон хөрш зэргэлдээ бусад ард түмний түүхийг судлахад түүхийн чухал эх сурвалж болохыг нягтлан судалсаар байна. Монгол улсын нутаг дэвсгэрт түрэг хэлтэн ард түмний соёлын хосгүй дурсгал болох Күл-Тегин, Билгэ-хаан, Тоньюкук, Моюунчур, Кули-чур, Тариатын түрэг бичээс зэрэг олон тооны дурсгал байдаг билээ.

Руни бичгийг тайлан унших түлхүүрийг В. Томсен, В. В. Радлов нар нээснээс хойш дэлхийн олон орны эрдэмтэд уг бичээсүүдийг унших, орчуулах зэргээр нарийвчлан судалж байна.

Монголд эртний түрэг бичгийн дурсгалыг судлах ажил 1950-аад оны үеэс зохион байгуулалттай эхэлсэн юм. Энэ завсар монголын эрдэмтэд түүх дурсгалын хайгуул шинжилгээг өргөн явуулж, руни бичгийн сан хөмрөгийг шинэ шинэ олдвороор улам бүр баяжуулж, тэдгээрийн тухай мэдээлэх, хэвлэн нийтлэх, тайлан унших, хооронд нь харьцуулах зэргээр эртний түрэг судлалыг хөгжүүлсээр ирлээ. Эртний түрэгийн гурван хаан (Элтерис, Капаган, Могилян) -ы төрийн зөвлөх байсан, тухайн үедээ цэцэн Тоньюкук (646—732) хэмээн алдаршсан хүн өөртөө зориулан босгосон хөшөөний үг, Могилян хаан (683—734), хун тайж Куле-Тегин (684—731)-д зориулан 732 онд босгосон хөшөөнд сийлсэн үгийг академич Б. Ринчен орос хэлнээс монгол хэлнээ орчуулсаныг түүхч Амар. «Монголын товч түүх» хэмээх (1924 он), номд нийтлүүлснээр энэ судалгаа эхэлжээ.

1950-иад оны үеэс шинжлэх ухааны байгууллагад мэргэжилтэй боловсон хүчин бий болж, эрдэм шинжилгээний хайгуулын ажил эрчимтэй хийх болсноор Монгол дахь эртний түрэг бичээсийг сурвалжлан цуглуулах, тайлж унших, судлах ажлын дараагийн үе шат эхэлжээ.

1956-57 онд Архангай аймагт явсан археологийн шинжилгээний ангийнхан Тариат сумын нутгаас хожим «Тариатын түрэг бичээс» гэж алдаршсан бичээсийн доод хэсгийг мөн Тамир сумын нутгаас «Бугатың бичээс-ийг олжээ».<sup>1</sup>

1956 онд А. Лувсандэндэв Монгол улсын төв номын санд байсан түрэг бичээсийг, Х, Пэрлээ Тайхар чулуун (Архангай аймаг)-ы зарим түрэг бичээсийг<sup>2</sup> судлан, 1957 онд Тоньюкукийн булшны шаваасан бичээсийг<sup>3</sup> Н. Сэр-Оджав олж С. Харжаубай,<sup>4</sup> тайлан уншсан, Дундговь аймгийн орон нутгийг судлах музейд хадгалагдаж байсан түрэг бичээсийг Х. Лувсанбалдан хэвлүүлснийг<sup>5</sup> Б. Базылхан тайлан уншиж нийтийн хүртээл болгов.<sup>6</sup>

\*ДДОУС-ын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор

1960-аад онд тус улсын нутаг дэвсгэр дэх эртний түрэг бичгийн дурсгалыг эрэн сурвалжлах, олдворуудыг Хэвлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхийн хамт «дурсгалт бичгийн чуулган» гэдэг цувралын 1968 оны дугаарыг тус улсын нутагт буй хадны бичиг, гэрэлт хөшөөний зүйлд зориулан гаргажээ<sup>7</sup>. Уг зохиолын оршилд академич Б. Ринчен бичихдээ «Манай орон эртний соёл-түүхийн дурсгалын зүйлээр баян бөгөөд зарим нэгэн зүйлийг нь европын эрдэмтэн олж, шинжин нийтэлснээр даяар алдаршин, монгол эрдэмтэн, бас нэгэн хэсэг шинээр олсон зүйлээ монгол хэлээр нийтэлсэн билээ. Гэвч манай улсын эртний түүхтэй холбогдолтой бөгөөд шинжлэх ухаанд мэдэгдээгүй дурсгалын зүйл бас цөөнгүй байна» гэж тэмдэглэжээ. Доктор Н. Сэр-Оджав «БНМАУ-д түрэг бичгийн дурсгалыг судалж байгаа нь» гэдэг өгүүлэл бичиж, энэхүү салбарт 1960-аад он хүртэл олсон ололтыг нэгтгэн дүгнэсэн байна. Энэ бүтээлд тус оронд буй хорин хоёр түрэг би чээсийн гэрэл зургийг нийтлүүлжээ. Урьд хэвлэгдсэн боловч олоход бэрх болсон бичээсүүдээс гадна Хагидайн хадны түрэг бичээс, дөрвийн түрэг бичээс, Тэсийн түрэг бичээс, Күл-Тегиний хөшөөний мэлхий чулуун суурь дээрх түрэг бичээс, Өвөр дөрвөлжин түрэг бичээс зэргийн гэрэл зургийг анх удаа энд нийтэлжээ. Энэ утгаараа уг бүтээл эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой юм. Энэхүү бүтээлд нийтлэгдсэн Хангидайн хад, Өвөр Дөрвөлж, Гурвалжин уулын түрэг бичээс болон мөн бусад олон түрэг бичээсийг Б. Базылхан уншиж тайлбарласан юм.<sup>8</sup>

Эртний түрэг бичээсийг сурвалжлан олох, судлахад Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний анги чухал үүрэг гүйцэтгэж байв. 1969 оноос хойш уг шинжилгээний анги эрэл хайгуулын ажлыг төлөвлөгөөтэйгээр гүйцэтгэж байлаа. Уг шинжилгээний анги «Тариатын (Тэрхийн) түрэг бичээс»-ийн зарим хэсгийг нөхөн олж,<sup>9</sup> Архангай аймгийн Хотонт сумын нутгаас Карабагасуны түрэг бичээс,<sup>10</sup> Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутгаас «Тэсийн түрэг бичээс»<sup>11</sup> зэргийг шинээр олж, Бигэр, Дарви, Цэнхэрмандал, Хутуг уул, Хангидын хад, Тэс, Архангайн түрэгийн бичээсийг дахин нягтлан үзэж, судалгааны ажлын үр дүнгээсээ нийтэлжээ.<sup>12</sup>

Эдгээр олон талт ажлын үр дүнд судалгаа шинжилгээний арга барил ч сайжирч 1970-аад оноос түрэг судлал нь бие даасан салбар болон хөгжих нөхцөл бүрдсэн байна. Түрэг судлаачдын бүтээл туурвил нь «Хэл зохиол», «Монголын судлал», «Түүхийн судлал», «Археологийн судлал» цувралуудад хэвлэгдэх болов. Мөн энэ үед хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нарын хийж гүйцэтгэсэн «БНМАУ-ын нутаг дахь түрэг бичээс» хамтын бүтээл хэвлэгдэв. (Д-р. Сэр-Оджавын «эртний түрэгүүд VI-VIII зуун, УБ. 1970). Зохиолч энэхүү номдоо 1970-аад он хүртэлх хугацаанд тус улсын нутгаас олдсон хэрэглэгдэхүүнийг судлан эрдэм шинжилгээний талаар ангилал цэгцэлж газар зүйн байдлыг тогтоосны зэрэгцээ түрэгийн эдийн ба оюуны боловсрол, төрийн түүхэн холбогдол бүхий олон асуудалд хариу өгчээ.

М. Шинэхүү «Тариатын гэрэлт хөшөө»-г нарийвчлан судлаад шинжилгээний ажлын дүнг 1975 онд «Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал»<sup>13</sup> гэдэг нэрээр Археологийн цувралын VI ботид нийтлүүлэв. Эртний түрэг бичгийг сонгодог монгол бичгийн хэлтэй харьцуулан судалсан явдалд эл зохиолын шинжлэх ухааны үнэ цэнэ оршиж байгаа юм. М. Шинэхүү Тариатын хөшөөний бичгийг тайлан уншаад хө шөөний үгийг утгын талаас ангилан үзжээ. Энэ нь хэлний харьцуулсан судлалд чухал ач холбогдолтой болсон байна. М. Шинэхүү мөн «Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал»<sup>14</sup> гэдэг ганц сэдэвт зохиол

бичиж хэвлүүлсэн юм. Энэ бүтээл удиртгал, Тариатын руни бичиг, Тэсийн руни бичиг, Карабалгасуны бичээсийг түүх, археологийн үүднээс судлан, монгол хэлээр орчуулан гаргажээ. Уг бүтээлийн өөр нэг ололт нь бичээсүүдийн доторх түүхэн мэдээ сэлтийг тухайн үеийн түүхийн үйл явдалд нарийн шинжилгээ хийхэд ашигласан явдал юм С. Харжаубай нь «Древнетюркские рунические надписи и тюрко-уй гурские этно-культурные связи в VII—IX вв.» хэмээх сэдвээр дэд докторын зэрэг хамгаалжээ. Түүний энэ бүтээл нь тус салбартаа чамбай зохиол болсон гэж шүүмжлэгчид үздэг.

С. Харжаубай «Уйгурын хаант улс» (МЭ-ний 745—760). хэмээх ганц сэдэвт зохиолдоо 745-840 онд тогтнож байсан эртний уйгурын хаант улсын эхний 20 жилийн (МЭ-ний 445-765) түүхийн талаар өгүүлжээ. БНМАУ-ын нутгаас олдсон уйгуруудын өөрсдийн үлдээсэн бичгийн дурсгалд Тэс, Тариат, Могойн шинэ усны хөшөөнүүдийн бичээсийг дахин нягтлан судалж, судалгааны гол тулгуур болгожээ. Тэрбээр Казахстанд «Чулуун дахь тэмдгүүд» өгүүлж байна<sup>15</sup> гэсэн өгүүлэл нийтлүүлжээ.

Эрдэмтэн Л. Болд «БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс» (УБ, 1990) хэмээх ном хэвлүүлсэн нь тус салбарын дорвитой ололтын нэг болов. Тус улсын нутаг дэвсгэрт буй түрэг бичээсийг судалсан байдал, гол судалгаануудад тулгуурлан нилээд бичээсийн утгын орчуулгыг энд тоймлон оруулсан байна.

Сүүлийн жилүүдэд манай түрэг судлаачид хөшөөний бичгийг монгол хэл, орчин цагийн утга зохиолын хэлээр орчуулаад зогсохгүй, монгол хэлтэй язгуурын казах хэлэнд давхар орчуулах, эртний түрэг бичгийн дурсгалын үгийн сан, үг зүйг тусгайлан судлах чимхлүүр ажлуудыг хийж байна. 1970-80 онуудад түрэг судлаачид эрдэм шинжил гээний томилот, шинжилгээний ангиар явж хадны бичээсүүдийг эрэн сурвалжлах, тайлан унших, орчуулах, тухайлбал «Орюн хааны түрэг бичээс» зэрэг шинэ олдворуудыг олон нийтэд мэдээлэх ажлыг үргэлжлүүлэн хийж, олон эрдэм шинжилгээний өгүүлэл илтгэл бичиж байна.<sup>16</sup>

Сүүлийн жилүүдэд монголын түрэг судлаачдын хийж буй дорвитой ажил бол «Монгол улсын нутаг дахь түрэг бичгийн атлас»-ыг зохиож хэвлэлд бэлтгэсэн явдал юм.

Монголд 130 мянган казах үндэстэн хүн ам оршин сууж ирсэн билээ. Тиймээс ч казах үндэстний хэл, утга зохиол, аман зохиол, угсаатны судлалыг хөгжүүлэх өндөр хариуцлагатай үүрэг монголын түрэг судлаачдын өмнө тавигдсан билээ. Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн археологийн шинжилгээний анги Баян-Өлгий аймгийн нутгаас урьд өмнө мэдэгдээгүй нилээд сонирхолтой дурсгалт зүйлийг олсон юм.<sup>17</sup> Б. Базылхан «Монгол-казах хэлний харьцуулсан түүхэн хэл зүй» хэмээх номоо 1973 онд Өлгий хотод хэвлүүлжээ. Уг номд өнөөгийн казах, Монгол хэлний үндсэн үгийн санд харь хэлнээс орсон үгийг эс тооцвол, эдгээр хэлний анхны үндэс нь нэг системд багтаж байна. Монгол хэлэнд казах хэл нь бусад түрэг хэлнүүдээс хамгийн ойр, эрт дээр үеэс олон талын харилцаатай байсан, материаллаг болон оюуны соёлын хувьд холбоотой нь харагдаж байна.

Түүний өөр нэг бүтээл нь «Эртний түрэг бичээсний Хэлний үгийн бүтэц (УБ. 1984) гэдэг ганц сэдэвт зохиол юм. Б. Базылхан энэ зохиолдоо түрэг, монгол судлаач нараас эртний түрэг бичгийн хэл ба монгол бичгийн хэлний үг зүйг судлахдаа одоо хүртэл ажиглаагүй нэг чухал үзэгдлийг, оноож хэлбэл эртний түрэг хэл ба монгол бичгийн хэлний бүтцийг нарийвчлан судалсан юм.

Доктор Б. Базылхан «Казах-Монгол хэлний толь» (УБ. 1977, 30000 үг), «Монгол-Казах Хэлний толь» (Өлгий. 1984, 100000 үг) зохио-

сон юм. Эдгээр толь нь монгол, казах хэлний орчин цагийн утга зохиолын хэлний хамгийн идэвхтэй хэрэглэгдэх үг, өвөрмөц хэллэг, нийгэм, улс төр, шинжлэх ухааны өргөн хэрэглэгдэх нэр томъёо орсон бөгөөд Монгол хэл сурах, судлах, казах хүнд: казах хэл сурах, судлах монгол хүнд түрэг монгол хэл болон алтай язгуурын хэл судлагч нарт чухал хэрэглэгдэхүүн болно. Б. Базылхааны «Казах-монгол хэлний толь»-ийг хэл шинжлэгч Г. Д. Санжеев<sup>18</sup> зохиолч М. Алимбаев<sup>19</sup> нар шүүмж бичиж өндрөөр үнэлсэн юм. Тус улсын казахын аман зохиол, орчин үеийн утга зохиолыг судлах ажил хийж байгаа эрдэмтэн бол доктор Х. Кабидаш билээ. «Устное народное творчество казахов, населяющих Баян-Ульгийских аймаг МНР» (Ульгий 1969) «Народная поэзия казахов Монголии» (Ульгий 1970), «Народные акыны казахов Монголии конца XIX в. начале XX века» (Ульгий 1972), «Харилцаа дуу болон 1, 2, 6, 8, 9, 10-р ангид үзэх монголын казахын уран зохиол хэмээх сурах бичгүүд хэвлэн гаргасан байна. Эдгээрт казахын ардын аман зохиол, тус нутгийн казахын өмнөх үеийн яруу найрагчдын бүтээлийг цуглуулан нийтэлж, судалсан байна. Х. Кабидаш казахын ард түмний аман зохиолын далай баян санг судлахад өөрийн тодорхой хувь нэмрээ оруулсаныг казахын нэрт эрдэмтэд М. Габдуллин, А. А. Маргулан нар тэмдэглэсэн билээ.<sup>20</sup>

Монгол Алтайн уулын казахын ард түмний түүхийг судлах талаар түүхийн ухааны доктор Х. Ислам ихээхэн хүчин чармайлт гарган, олон бүтээл туурвижээ. Тэрээр «Керейдийн түүхэн замнал» (Ульгий 1977), «БНМАУ-ын казахын ард түмний түүх» (Өлгий, 1979) зэрэг ном зохиолдоо тус нутгийн ард түмний түүхийг тодорхой судлан гаргаж тавьснаараа ач холбогдолтой болжээ. Монгол дахь казахын түүхийг судлах талаар А. Сарай зарим ажил хийж «Монгол казахын түүхийн зарим асуудал» ном хэвлүүлэн, одоогийн нутагтаа казахуудын суурьшсан түүхийг эрдэм шинжилгээний нотолгоотой үзүүлсэн юм. Мөн түүний «Казахын ард түмэн ардын хувьсгалын өмнө» (УБ. 1991) хэмээх ном нь хэвлэгдэв. Энд тус нутгийн казахууд Баруун Монголд суурьшсанаас хойш 1921 он хүртэлх түүхийг нарийвчлан судалснаараа онцлог юм.

Баян-Өлгий аймаг байгуулагдсан 1940 оноос 1980 он хүртэлх 40 жилийн хугацаанд аймгийн амьдралд тохиолдсон томоохон үйл явдлыг он дарааллын журмаар тусгаж харуулсан А. Кажеберийн «Баян-Өлгий аймгийн он дарааллын бичиг» (Өлгий 1979) ном нь чухал ач холбогдол бүхий, сурвалж материал юм.

Эндхийн казахын ард түмний хүүхэд хүмүүжүүлэх ардын сурган хүмүүжүүлэх зүйн тухай» (Өлгий, 1976) болон түүний бусад ном, казах ардын тоглоомын талаарх Ж. Мизамханы «Ардын тоглоом, түүний сурган хүмүүжүүлэх үндэс» (Өлгий, 1982) ном нь энэ салбарын байдлыг харуулж чадна.

1940 оноос казах хэлээр кирилл үсгээр тэмдэглэсэн сонин, сэтгүүл, ном зохиол хэвлэгдэн гарчээ. Баян-Өлгийд МЗЭ-ийн салбар ажиллаж олон тооны зохиолчид зохиолоо казах, монгол хэлээр туурвиж байна. Монголын казах уран зохиолын ололт, хөгжлийн дүр төрх, агуулга хэлбэр, өнөөгийн түвшинг харуулахуйц шилдэг бүтээлийн дээжээс «Халык акындары» (Ардын найрагчид) «Айтыс» (Харилцаа дуу) «Алтай баурайында» (Алтайн энгэрт) өгүүллэг тууж, «Ховдо толкыны» «Ховдын долгио» зэрэг дөрвөн ном хэвлэгдэв. Баян-Өлгийн зохиолчид, яруу найргийн шилдэг бүтээлээс орсон «Баян-Өлгийн зохиолчдын уран зохиолын дээж» хэмээх томоохон цуврал хэвлэгдэв. Өнгөрсөн 30 жилд Баян-Өлгий аймгийн нийт 70 гаруй зохиолч, яруу найрагчдын 250 ном, роман, тууж, өгүүллэг хэвлэгджээ. Мөн казах

хэлээр 30, монгол хэлээр 30 илүү эмхтгэл гарчээ. Энэ нь казахуудын оюуны соёлд гарсан томоохон ололт болох нь тодорхой юм.

Орчин үеийн казахын уран зохиолын түүх, судлал шүүмжлэлд зориулагдсан зарим ажил хийгджээ. Үүнд Х. Кабидашийн «Шинэчлэгдсэн нутгийн шинэ утга зохиол» (Өлгий, 1976) ном хэвлэгдэв. Утга зохиолын судлал, шүүмжлэлд зориулагдсан уг номд монгол, казахын ард түмний найрамдал аман зохиолд хэрхэн туссан хийгээд нутгийн уран зохиолын хөгжлийн зарим асуудлыг судлахад зориулсан юм. Эдгээр бүтээлд монгол дахь казахын зохиолчдын бүтээлийг задлан шинжилж судлах эхийг тавьсны хувьд үнэ цэнтэй болсон юм.

И. Якийн «Зохиолчийн үүрэг» (1979) номд шинэ утга зохиолын үргэлжилсэн үг, яруу найраг, яруу найрагчдын уран бүтээлд задлан шинжилгээ хийх замаар тус нутгийн уран зохиолын өсөлт, хөгжилтийн зам, үзэл санаа, уран сайхны чанарт дүгнэлт хийж, санал дэвшүүлсэн. Мөн түүний «Уран чанарын түвшин (1965) ном дээрх сэдвийг үргэлжлүүлсэн зүйл юм. Ж. Хуангааны «шүүмжлэлийн учир» (1985) ном нь мөн судлал шүүмжлэлд зориулагдсан байна. Түүний «Бабын Ахтааны яруу найраг» (1985) номд нэрт яруу найрагчийн яруу найргийн зохиолыг тусгайлан судалсан байна. Мөн нэрт яруу найрагч Б. Ахтааны уран бүтээлийн талаар Б. Бааст<sup>21</sup>, Ц. Хасбаатар<sup>22</sup>, Б. Имашхан<sup>23</sup>, Б. Явуухулан<sup>24</sup>, Х. Шабдарбай<sup>25</sup>, К. Кабидаш<sup>26</sup> нар хэд хэдэн судалгааны өгүүлэл бичжээ. Д. Цэнд<sup>27</sup>-ийн бичсэн Баян-Өлгий аймгийн казах хэлний уран зохиолын яруу найргийн тухай эрдэм шинжилгээний өгүүллүүд гарсан байна.

Баян-Өлгий аймгийн казах ардын дуу хөгжим, орчин үеийн дуу хөгжмийг судлах талаар зарим ажил хийгджээ. Ардын дууг цуглуулан домбор, цуурын аялгуу зэргийг нотод буулгах талаар А. Кабкей<sup>28</sup>, А. Ахметбек<sup>29</sup>, С. Магауия<sup>30</sup> нар нилээд зүйлийг хэвлэж нийтэлжээ.

А. Кабыкейн эмхэтгэн Өлгий хотод 1983 онд хэвлүүлсэн «Монголын казахын ардын дуунууд», 1977 онд гаргасан «Ардын аялгуу» ном нь дорвилот бүтээл болов. К. Телеухан, Т. Исак нарын бичсэн. «Баян Өлгий аймгийн хөгжмийн соёл» (1981) Ном нь ардын хөгжмийн ур, уран бүтээлчидтэй танилцуулан, ХДТ-ын тухай өгүүлсэн байна. Энэ нь аймгийн хөгжмийн соёлын хөгжлийг нэгтгэн судалснаараа үнэ цэнтэй юм.

Казахын материаллаг соёл, тухайлбал, гар урлалын материалыг цуглуулах ажил нилээд хийгдэв. Үүнд Алтангэрэл «Казах ардын үндэсний хээ альбомыг 1977 онд Улаанбаатар хотод хэвлүүлэв. Мөн Х. Шобай «Казах, урианхайн ардын гар урлал», «Казах ардын үндэсний хээ» альбом хэвлүүлжээ. Түүнд 103 хээ угалз орсон бөгөөд энэхүү жижигхэн бүтээлийг Казахстаны урлаг судлаач Лайла Актаева өндөр үнэлсэн байдаг. Ардын төр, засгаас монгол улсын казахын ард түмний түүх, соёлыг судлах асуудалд ямагт анхаарсаар ирсэн бөгөөд казахын ард түмний хувьсгалын болон өмнөх үеийн түүх, угсаатны зүй, хэл зохиолыг судлах ажлыг өргөтгөн эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөнд оруулж судлахыг чухалчлан зааж байжээ.

Түүнийг цаашид хэрэгжүүлэхэд ШУА-ийн Тэргүүлэгчид, Баян-Өлгий аймгийн АДХГЗ-ны 1988 оны 9-р сарын 6-ны өдрийн хамтарсан тогтоолын дагуу казах хэл, уран зохиол, түүх, угсаатны зүйн судлалыг цаашид эрчимжүүлэх зорилгоор Баян-Өлгий аймагт казах, түрэг судлалын сектор байгуулсан бөгөөд ажлаа эхэлсэн нь чухал үйл явдал болов?

ШУА-ийн түүх, хэл зохиолын хүрээлэнгийн харьяа энэ секторыг эрдэм шинжилгээний боловсон хүчнээр бэхжүүлэх судалгаа шинжил-

ний ном, хэрэглэгдэхүүнээр хангах талаар зарим арга хэмжээ авлаа. Үүний зэрэгцээ арван жилийн сургуулиудад казах болон монгол хэл заах агуулгыг тогтоох, сурах бичиг зохиож нийтийн хүртээл болгоход эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудыг зохион байгуулалттай оролцуулж байна.

Дээрх секторт 1989-1990 онд казах хэл, аялгуу, уран зохиол, аман зохиолын талаар хийх судалгааны гол зорилт нь Баян-Өлгийн казахуудын хэл аялгууг судлах хэрэглэгдэхүүн цуглуулж, хам, цуваа цагийн судалгаагаар онолын нэгтгэсэн дүгнэлт хийсэн ганц сэдэвт зохиол бичих, Казахстаны эрдэмтэдтэй хамтран хоёр талын хамтын ажиллагааны дагуу Алма-Атад хэвлүүлэх «Казах аялгууны толь»-д тэндхийн казахуудын нутгийн аялгууны үгсийн сангийн ялгаатай болон өвөрмөц үгсийг оруулах, казахын аман зохиолын зүйлээс туульс, үлгэр домог, зүйр цэцэн үгсийн судалгааны хэрэглэгдэхүүн цуглуулж, ганц сэдэвт зохиол бичих, орчин үеийн казах уран зохиолын үүсэл хөгжил, түүхэн асуудлыг судлан боловсруулах, казах, монгол хэлийг оновчтой зааж сургах, бага, дунд, ахлах ангид ногдох цагийн бүтэц, хуваарийг нэг мөр болгох явдал болно. «БНМАУ-ын нутаг дахь казахуудын хэл аялгуу» сэдэвт ажлын авиа зүй, үг зүй, үгсийн сангийн хэсгээс дөрвөн хэвлэлийн хуудас зүйл бичиж боловсруулаад байгаа бөгөөд үүнд казахын утга зохиолын хэлийг казах хэлний бусад аман аялгуутай харьцуулан авч үзжээ.

«Казахын ардын аман зохиол» сэдэвт ажилд холбогдох хэрэглэгдэхүүн цуглуулж монгол ардын аман зохиолтой харьцуулан судалж байна. Түүнчлэн казахын орчин үеийн утга зохиолын түүхэн хөгжлийг судлах зорилгоор урьд өмнө нь гарсан судалгааны ажлыг нэгтгэн дүгнэжээ.

Баян-Өлгий аймагт казах, түрэг судлалын ажлыг эрчимжүүлэхэд гадаад харилцаа ч чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй юм. 1989 оноос Баян-Өлгий аймагт Казах улсын Семипалатинск муж, Шинжлэх ухааны академи, Зохиолчдын Эвлэлийн хороотой шууд харилцаатай болсон юм. Энэ нь түрэг судлалын ажлыг эрчимтэй явуулахад сайн нөлөө үзүүлэх юм.

Манайд К. Бихумар, Ж. Хуангаан, М. Озила, Д. Лиза, Ш. Хуланда, Б. Напил, Х. Досымбек, К. Бабакумар, Б. Ерболат, А. Абдикарим нарын хүмүүс казах түрэг судлалаар ажиллаж байна. Мөн түүнчлэн Туркийн дорно дахин судлаачидтай хамтын ажиллагаа өргөжиж байна.

Монгол улсад хөгжиж буй казах, түрэг судлалын өнөөгийн байдлыг товч хөндвөл ийм байна. Гэвч судлаачдын өмнө тавигдах зорилт өндөр, энэхүү салбарыг эрчимтэй хөгжүүлэн дэлхийн судлалын түвшинд судалгаагаа үргэлжлүүлэн явуулах шаардлага тулгарч байна.

Сүүлийн хэдэн жилд манай оронд өрнөсөн ардчиллын ачаар түрэг судлалын шинэ үе эхлэв. Олон зуун жилийн түүхтэй түрэг, Монголын ард түмний уламжлалт харилцааг сэргээн хөгжүүлэх таатай боломж нээгдлээ. Турк, Казах, Өзбек, Кыргыз, - Азербайжан, Туркмен улс болон ОХУ-ын Тува, Саха улстай тогтоосон харилцаа хамтын ажиллагаа гүнзгийрэн хөгжиж байна.

Өнөө үеийн энэхүү байдал нь олон улсын түрэг-монгол судлалын төвийг Монгол улсад байгуулахад түлхэц болсон юм. Энэхүү төв нь Алтайн судлал, Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн хүрээнд бүхий л асуудлыг анхааран судалж, сурталчлах явдал юм. Тус төв нь үйл ажиллагаагаа эхлэн Турк, Казах, Кыргыз, Өзбек, БНХАУ-ын тийм чиглэлийн байгууллагуудтай харилцаа тогтоон, эрдэм шинжилгээний

тодорхой ажлуудыг эрчимтэй хийж байна. Одоо Казах, Түрэг судлалын тус төв нь Төв Азийн нүүдлийн соёл иргэншлийн асуудлаар 1994 онд Олон улсын эрдэм шинжилгээний хурал хийхээр бэлтгэж байгаа болно.

- 1 Ц. Доржсүрэн, 1956–57 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай. УБ. 1958, т. 19
- 2 А. Лувсандэндэв. «Шинээр олдсон түрэг бичээсийн тухай» УБ. 1956
- 3 Х. Пэрлээ. Тайхар чулуу. УБ. 1960, т. 21—24
- 4 Н. Сэр-Оджав, Шинээр олдсон түрэг бичээсийн тухай «SA». Т. 1. fasc 4
- 4 Н. Сэр-Оджав. Шинээр олдсон түрэг бичээсийн тухай. УБ. 1960, т. 4, Харжаубай. Эртний түргийн гурван бичээс, 1977 «SA»
- 5 Х. Лувсанбалдан, «Өчүүхэн түрэг бичээсийн тухай» ШУАМ, 1962, № 4 62-р тал
- 6 Б. Базылхан. Эртний түрэг бичээстэй мутрын тэмдэг. ШУАМ, 1964, № 1 74-75
- 7 Б. Ринчин, Монгол нутаг дахь хадны бичээс гэрэлт хөшөөний зүйл. УБ. 1968
- 8 Б. Базылхан. Күл-Тегиний хөшөөний мэлхий чулууны түрэг бичээс. Мөн түүний «Эртний түрэг бичээстэй чагт» ШУАМ, № 4, 1966, т. 74-75, Хангидайн хадны түрэг бичээс, ШУАМ, № 1, 1969 т. 28—29
- 9 М. Шинэхүү. Памятник рунической письменности из Тариата, «Роль кочевых народов в цивилизации центральной Азии. УБ. 1974, т. 327-331, мөн түүний Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал, 1975, Б. Базылхан «Тэрхийн түрэг бичээс» 1—55 УБ. 1980 г., 163—175 «SA». т. VIII. 15
- 10 М. Шинэхүү. Новый памятник рукописей письменности уйгурского карабалгасуна. ОУМЭ, III их хурал III боть. УБ., 1979, т. 301-305, мөн түүний «Орхон Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал», «SA» Т УБ, 1980
- 11 С. Харжаубай. Тэсийн гэрэлт хөшөө, ХЗ, УБ. 1979
- 12 М Шинэхүү. Бигэрийн түрэг бичээс, ШУАМ. 1971 № 1 т. 37-40, «Дарвийн эртний түрэг бичээс» 3-13 1972. т. 145—150. «Цэнхэр мандлын эртний түрэг бичээсийг дахин уншсан нь» 1—9, УБ. 1977 х 97, 113 «Хутаг уулын түрэг бичээс ШУАМ, 1976, No 4 т. 36-41
- "Хангидайн хадны түрэг бичээсийг дахин нягталсан нь» ХЗС УБ. 1979 № 1-15, «Тэсийн эртний түрэг бичээсийг дахин нягталсан нь» С. Хажубай «Надпись на скале Арханана «ХЭС» XVI боть. 1—25 дэвтэр. УБ. 1984, т. 90—93 «Эртний гурван бичээс» VII 10—18 УБ. 1979, т. 32—35
- 13 Археологийн судлал УБ. 1975
- 14 Археологийн судлал УБ. 1980
- 15 С. Хажубай. Чулуун дахь тэмдгүүд өгүүлж байна. «Билим жане өнбек» 1984, № 2
- 16 Л. Болд «БНМАУ-ын эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал» ШУАМ, 1986, № 3, 65—88
- 18 Известия АН Казахской ССР. Серия филологическая А. А. 1979, № 3 с. 57—59
- 19 «Билим жэне өнбек» 1984, № 10
- 20 Жана талап. 1974, № 1
- 21 Б. Бааст. Манай нэрт яруу найрагч, Утга зохиол урлаг. 1972
- Б. Бааст, Ардын билэгт дууч. Утга зохиол, урлаг. 1968, № 18
- 22 Ц. Хасбаатар, Ардын билэгт найрагч. Цог. 1974, № 3 1
- 23 Б. Имшхан, Найрагчийн баяр «Шуила» 1972, I (казах хэлээр)
- 24 Б. Явуухулан «Хөх сүмбэр оргил» Соёл утга зохиол, 1955; № 27
- 25 Х. Шабдарбай. Бүргэд найраглалын тухай. Шугила (казах хэлээр)
- 26 Х. Кабидаш, Б. Ахтааны уран бүтээл Цогч. 1973, № 3
- 27 Д. Цэнд. Баян-Өлгий аймгийн казах хэлний уран зохиолын яруу найргийн бүтээлийн тухай. Цог. 1980, № 5. Мөн түүний казах яруу найрагчдын бүтээлийн тухай. Утга дохиол, урлаг, 1987, I. х 725
- 28 А. Кабыкей Монголын казахын ардын дуунууд. Өлгий, 1983, Мөн түүний дуу.
- 29 А. Кабыкей. А. Ахметбек. Монгол казахуудын ардын дуу. Өлгий, 1965 (казах хэлээр) Өлгий 1972 (казах хэлээр)
- 30 С. Магауяи. Казах ардын дууны үг. Өлгий 1982 (казах хэлээр)